



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ᠰᠣᠩᠭᠢᠨᠬᠠᠶᠢᠷᠬᠠᠨ
ᠳᠦᠦᠷᠭᠢᠨ
ᠰᠤᠲᠤᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ
ᠬᠡᠯᠲᠡᠰ

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2025 он



Улаанбаатар хот 2026 он



ГЭМТ ХЭРЭГ

2025 онд 89522 дуудлага, мэдээлэл хүлээн авсан нь өмнөх оны мөн үеэс 1382(1.5%) нэгжээр буурсан.

ХҮСНЭГТ 1. БҮРТГЭГДСЭН ДУУДЛАГА МЭДЭЭЛЛИЙН ТОО, ЖИЛЭЭР

Хэлтэс	Хүлээн авсан дуудлага мэдээлэл		Өсөлт бууралт хувь	
	2024	2025	Тоо	Хувь
Нийт	90 904	89 522	1 382	-1.5
I хэлтэс	44 969	45 565	596	1.3
II хэлтэс	24 799	23 775	1 024	-4.1
III хэлтэс	21 172	20 182	990	-4.7

Нийт хүлээн авсан дуудлага, мэдээллийн 5261(5.8%) гэмт хэргийн, 74440(83.1%) зөрчлийн, 981(1.1%) зарлан мэдээлэл, 8840(9.8%)хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээлэл байна. Гэмт

хэргийн шинжтэй дуудлага, мэдээлэл нь өмнөх оны мөн үеэс 338(6.8%), хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээлэл 1638(22.7%) тус тус өссөн байна. Харин зарлан мэдээлэл 14(1.4%), зөрчлийн шинжтэй дуудлага мэдээлэл 3374(4.3%) тус тус буурсан байна.


ХҮСНЭГТ 2. ХҮЛЭЭН АВСАН ГОМДОЛ МЭДЭЭЛЛИЙН ТОО, ЖИЛЭЭР

Хэлтэс	Нийт хүлээн авсан гомдол мэдээлэл		Өсөлт, бууралт	
	2024	2025	Тоо	Хувь
Нийт	42 578	36 235	6 343	-14.8
I хэлтэс	22 662	18 631	4 031	-17.7
II хэлтэс	12 513	10 223	2 290	-18.3
III хэлтэс	7 403	7 381	22	0.2


2025 онд 36235 гомдол, мэдээлэл шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 6343(14.8%) буурсан байна. Нийт хүлээн авсан гомдол мэдээллийн 15001(41.3%) гэмт хэргийн шинжтэй, 21234(58.6%) зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна.

ЗУРАГ 1.

ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ



ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ



Сонгинохайрхан дүүрэг нь 96524 өрхийн 343439 хүн амтай бөгөөд 2025 оны байдлаар дүүргийн хэмжээнд 5 182 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1 284(32.9%) хэргээр өссөн байна. Гэмт хэргийн илэрүүлэлт 48.7 хувьтай байна

Тайлант хугацаанд гарсан нийт гэмт хэргийн 4470(86.3%) нь хөнгөн, 712(17.3%) нь хүнд гэмт хэрэг эзэлж байна. Гэмт хэргийн ангилалыг өмнөх онтой харьцуулбал хөнгөн 1124(33.6%) гэмт хэргээр, хүнд 160(30.0%) гэмт хэргээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 3. БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, гэмт хэргийн ангилал, жилээр

Үзүүлэлт	Бүх гэмт хэрэг				Гэмт хэргийн ангилал							
	2024	2025	Өсөлт, бууралт		Хөнгөн				Хүнд			
			тоо	хувь	2024	2025	Өсөлт, бууралт		2024	2025	Өсөлт, бууралт	
							тоо	хувь			тоо	хувь
Нийт	3 898	5 182	1 284	32.9	3 346	4 470	1 124	33.6	552	712	160	29.0
I хэлтэс	1 747	2 307	560	32.1	1 486	1 952	466	31.4	261	355	94	36.0
II хэлтэс	1 196	1 464	268	22.4	1 001	1 229	228	22.8	195	235	40	20.5
III хэлтэс	955	1 411	456	47.7	859	1 289	430	50.1	96	122	26	27.1

2025 оны байдлаар бүртгэгдсэн нийт хэргийн 2307(44.5%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 1464(28.3%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 1411(27.2%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст харъяалагдаж байна.

ЗУРАГ 2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛД АВТСАН ХОХИРОГЧИЙН ТОО, дүүргээр



Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт гэр бүлийн хүчирхийлэлд автсан хохирогч 114 байгаа нь өмнөх оны мөн үеэс 15(12.5%) хүнээр өссөн байна. Нийслэлд нийт гэр бүлийн хүчирхийлэлд автсан хохирогчийн 114(15.2%) нь сонгинохайрхан дүүргийнх байна.

2025 онд нийслэл хотод нийт 33144 хэрэг бүртгэгдсэний 5182(15.6%) гэмт хэрэг Сонгинохайрхан дүүрэгт ногдож байна. Нийслэл хотод гарсан нийт хэргийн 29512(89.0%) хөнгөн гэмт хэрэг, 3632(11.0%) хүнд гэмт хэрэг байна. Нийслэлд гарсан нийт хөнгөн гэмт хэргийн 4470(15.1%), хүнд гэмт хэргийн 712(19.6%) хувь нь тус дүүрэгт ногдож байна.

ХҮСНЭГТ 4.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, дүүргээр, жилээр


Дүүрэг	Гэмт хэргийн ангилал								
	Бүх хэрэг			Хөнгөн			Хүнд		
	2024	2025	Өсөлт, бууралт %	2024	2025	Өсөлт, бууралт %	2024	2025	Өсөлт, бууралт %
Нийслэл	32 123	33 144	3.2	29 239	29 512	0.9	2 884	3 632	25.9
Баянгол	5 974	4 765	-20.2	5 617	4 447	-20.8	357	318	-10.9
Баянзүрх	8 702	8 017	-7.9	8 015	7 107	-11.3	687	910	32.5
Сүхбаатар	4 458	5 196	16.6	4 085	4 664	14.2	373	532	42.6
Сонгинохайрхан	3 898	5 182	32.9	3 346	4 470	33.6	552	712	29.0
Хан-уул	5 101	5 465	7.1	4 689	4 932	5.2	412	533	29.4
Чингэлтэй	3 369	3 801	12.8	2 957	3 377	14.2	412	424	2.9
Багануур	286	374	30.8	243	255	4.9	43	119	176.7
Багахангай	20	30	50.0	16	15	-6.3	4	15	3.7**
Налайх	315	314	-0.3	271	245	-9.6	44	69	56.8

Тайлбар: ** дахин их

2025 онд нийслэл хотод 33144 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 1021(3.2%) хэргээр өссөн байна. Нийт гарсан хэргийн 4765(14.4%) нь Баянгол, 8017(24.2%) нь Баянзүрх, 5196(15.7%) нь Сүхбаатар, 5182(15.6%) нь Сонгинохайрхан, 5465(16.5%) нь Хан-уул, 3801(11.5%) нь Чингэлтэй, 374(1.1%) нь Багануур, 30(0.1%) нь Багахангай, 314(0.9%) нь Налайх дүүрэгт тус тус гарсан байна.

ЗУРАГ 3.

ГЭМТ ХЭРГИЙН ТОО, дүүргээр



ХҮСНЭГТ 5.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, ХЭРГИЙН АНГИЛЛААР

Үзүүлэлт	Он	хүний амьд явах эрхийн эсрэг	Хүнийг алах			хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах			хүний бэлгийг эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	Хүчиндэх	
			хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Хүний амь насыг болгоомжгүйгээр хохироох	хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах		хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах	гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	хүчиндэх		Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	
Сонгинохайрхан	2024	107	24	75	8	967	53	769	9	92	73	7
I хэлтэс		60	17	38	5	504	30	388	5	53	42	4
II хэлтэс		32	5	25	2	275	11	225	2	28	21	3
III хэлтэс		15	2	12	1	188	12	156	2	11	10	0
Сонгинохайрхан	2025	114	14	94	3	999	56	844	10	110	88	7
I хэлтэс		67	4	58	3	559	27	486	4	64	51	3
II хэлтэс		36	7	28	0	255	13	208	5	35	27	4
III хэлтэс		11	3	8	0	185	16	150	1	11	10	0
Өсөлт, бууралт хувь		6.5	-41.7	25.3	-62.5	3.3	5.7	9.8	11.1	19.6	20.5	0.0

2025 онд Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 114(2.2%) нь хүний амьд явах эрхийн эсрэг, 999(19.3%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 110(2.1%) нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, 25(0.7%) нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг, 14(0.4%) нь эдийн засгийн, 102(2.0%) нь олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг, 21(0.4%) нь нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг, 17(0.3%) нь хүрээлэн байгаа байгаль орчны эсрэг, 41(0.8%) нь Кибер аюулгүй байдлын эсрэг, 2(0.04%) нь хүүхдийн эсрэг, 330(6.4%) нь хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг хэргүүд байна.

ХҮСНЭГТ 5.


ҮРГЭЛЖЛЭЛ

Үзүүлэлт	Он	хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн эсрэг	хүүхдийн эсрэг	эдийн засгийн	Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхолын эсрэг	Мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг	нийтийн албаны ашиг сонирхолын эсрэг	хүрээлэн байгаа байгаль орчны эсрэг	Кибер аюулгүй байдлын эсрэг	Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслэлийн ашиглалтын журмын эсрэг
I хэлтэс	24	2	9	18	12	3	8	15	19	133	
II хэлтэс	7	1	2	13	8	1	5	2	5	59	
III хэлтэс	5		5	8	3		3		15	34	
Сонгинохайрхан	2025	36	2	16	102	42	4	21	17	41	330
I хэлтэс		22	1	8	42	19	3	13	15	19	198
II хэлтэс		4		4	33	13		7		12	82
III хэлтэс		10	1	4	27	10	1	1	2	10	50
Өсөлт, бууралт хувь		0.0	-33.3	0.0	2.6**	82.6	0.0	31.3	0.0	5.1	46.0

Тайлбар: ** дахин их

ЗУРАГ 4.

ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН БАЙДЛААР, дүүргээр



ХҮСНЭГТ 6.

ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ТОО, төрлөөр


Үзүүлэлт	Он	Өмчлөх эрхийн эсрэг									
		Хулгайлах	Хувийн өмч хулгайлах	Автотээврийн хэрэгслэл хулгайлах	Халаасны хулгай	Дээрэмдэх	Залилах	Хөрөнгө завших	эд хөрөнгө устгах, гэмтээх	мал хулгайлах	
Сонгинохайрхан	2024	2 329	730	463	37	81	126	1 122	55	115	11
I хэлтэс		894	215	129	13	17	39	470	30	58	11
II хэлтэс		765	274	192	10	8	46	353	15	29	
III хэлтэс		670	241	142	14	56	41	299	10	28	
Сонгинохайрхан	2025	3 382	812	562	44	67	169	2 080	58	96	12
I хэлтэс		1 292	292	177	25	23	52	779	39	45	12
II хэлтэс		996	279	227	3	5	33	610	11	25	
III хэлтэс		1 094	241	158	16	39	84	691	8	26	
Өсөлт, бууралт хувь		45.2	11.2	21.4	18.9	-17.3	34.1	85.4	5.5	-16.5	9.1

2025 онд гарсан өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 1292(38.2%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 996(29.5%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 1094(32.3%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус харьяалагдаж байна.

2025 оны байдлаар нийт 5182 гэмт хэрэг бүртгэгдсэний 3382(65.3%) өмчлөх эрхийн эсрэг хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1053(45.2%) хэргээр өссөн байна.Тайлант хугацаанд нийт өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 812(24.0%) нь хулгайлах гэмт хэрэг, 169(5.0%) нь дээрэмдэх, 2080(61.5%) нь залилах, 58(1.7%) нь хөрөнгө завших, 96(2.8%) нь эд хөрөнгө устгах гэмтээх, 12(0.4%) нь мал хулгайлах хэрэг байна. Хулгайлах гэмт хэргийн 562(69.2%) нь хувийн өмч хулгайлах, 67(8.3%) нь халаасны хулгайн гэмт хэрэг байна. Хувийн өмч хулгайлах гэмт хэргийн 44(7.8%) нь автотээврийн хэрэгслэл хулгайлах гэмт хэрэг байна. 2025 онд бүртгэгдсэн нийт хулгайлах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 72(11.2%) хэргээр, дээрэм 43(34.1%), залилах гэмт хэрэг 958(85.4%) гэмт хэргээр тус тус өссөн байна. Харин халаасны хулгай өмнөх оны мөн үеэс 14(17.3%) хэргээр, эд хөрөнгө устгах гэмтээх гэмт хэрэг 19(16.5%) хэргээр тус тус буурсан байна.

ЗУРАГ 5.

ӨМЧЛӨХ ЭРХИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, дүүргээр



ХҮСНЭГТ 7.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАРАГААР

Үзүүлэлт	Он	Нийт гэмт хэрэг	Гараг						
			Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Сонгинохайрхан	2024	3 898	604	606	660	538	531	447	512
I хэлтэс		1 747	294	285	294	247	248	199	180
II хэлтэс		1 196	155	177	215	158	149	141	201
III хэлтэс		955	155	144	151	133	134	107	131
Сонгинохайрхан	2025	5 182	865	831	762	779	741	588	616
I хэлтэс		2 307	379	378	338	361	358	255	238
II хэлтэс		1 464	230	228	225	234	198	145	204
III хэлтэс		1 411	256	225	199	184	185	188	174
Өсөлт, бууралт хувь		32.9	43.2	37.1	15.5	44.8	39.5	31.5	20.3

2025 онд Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн нийт хэргийн 865(16.7%) нь Даваа гарагт, 831(16.0%) нь Мягмар гарагт, 762(14.7%) нь Лхагва гарагт, 779(15.0%) нь Пүрэв гарагт, 741(14.3%) нь Баасан гарагт, 588(11.4%) нь Бямба гарагт, 616(11.9%) нь Ням гарагт тус тус гарсан байна. Даваа гарагт хамгийн их хэрэг гарсан бөгөөд Бямба, Ням гарагт хамгийн бага хэрэг гарчээ. Гарсан гэмт хэргийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулбал Даваа гарагт гарсан хэрэг 261(43.2%), Мягмар гарагт гарсан хэрэг 225(37.1%), Лхагва гарагт гарсан хэрэг 102(15.5%), Пүрэв гарагт гарсан хэрэг 241(44.8%), Баасан гарагт гарсан хэрэг 210(39.5%), Бямба гарагт гарсан хэрэг 141(31.5%), Ням гарагт гарсан хэрэг 104(20.3%) гэмт хэргээр тус тус нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 9.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ЦАГААР

Үзүүлэлт	Он	Нийт гэмт хэрэг	Цаг			
			06-14	14-19	19-22	22-06
Сонгинохайрхан	2024	3 898	1 269	1 099	670	860
I хэлтэс		1 747	430	495	370	452
II хэлтэс		1 196	457	321	184	234
III хэлтэс		955	382	283	116	174
Сонгинохайрхан	2025	5 182	1 956	1 402	751	1 073
I хэлтэс		2 307	731	640	384	552
II хэлтэс		1 464	578	389	227	270
III хэлтэс		1 411	647	373	140	251
Өсөлт, бууралт хувь		32.9	54.1	27.6	12.1	24.8

Тайлант хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн 1956(37.7%) нь 06-14 цагийн хооронд, 1402(27.1%) нь 14-19 цагийн хооронд, 5751(14.5%) нь 19-22 цагийн хооронд, 1073(20.7%) нь 22-06 цагийн хооронд тус тус гарсан байна. Тайлант хугацаанд гарсан хэргийн байдлаас харахад 06-14 цагийн хооронд хамгийн их хэрэг гарсан бол 19-22 цагийн хооронд хамгийн бага хэрэг гарсан байна. 06-14 цагийн хооронд гарсан гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 687(54.1%) гэмт хэргээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 8. ГЭР, ОРОН СУУЦАНД ҮЙЛДЭГДСЭН ХЭРЭГ

Үзүүлэлт	Он	гэр, орон сууц						
		гэр	орон сууцны байр	хувийн байшин	зуслангийн байшин	нийтийн байр	орц	
Сонгинохайрхан	2024	1 411	645	332	250	33	31	12
I хэлтэс		611	316	115	109	18	11	2
II хэлтэс		513	263	67	98	14	10	2
III хэлтэс		287	66	150	43	1	10	8
Сонгинохайрхан	2025	1 994	676	759	316	74	40	18
I хэлтэс		725	347	154	123	21	12	6
II хэлтэс		554	230	102	140	48	11	3
III хэлтэс		715	99	503	53	5	17	9
Өсөлт, бууралт хувь		41.3	4.8	2.3**	26.4	2.2**	29.0	50.0

Тайлбар: ** дахин их

2025 онд бүртгэгдсэн нийт хэргийн 1994(38.5%) нь гэр орон сууцанд гарсан хэрэг бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 583(41.3%) хэргээр өссөн байна. Тайлант хугацаанд нийт гэр орон сууцанд гарсан хэргийн 676(33.9%) нь гэрт, 759(38.1%) нь орон сууцны байранд, 316(15.8%) нь хувийн байшинд, 74(3.7%) нь зуслангийн байшинд, 40(2.0%) нь нийтийн байранд, 18(0.9%) нь орцонд тус тус гарсан байна.

Тайлант хугацаанд нийт гэр, орон сууцанд гарсан хэргийн 725(36.4%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 554(27.8%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 715(35.8%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 10. ГУДАМЖ, ТАЛБАЙД ҮЙЛДЭГДСЭН ХЭРЭГ

Үзүүлэлт	Он	Гудамж, талбай						
		гэр хорооллын гудамж	орон сууцны хороололын гудамж	Тоглоомын талбай	ил зогсоол	автобусны буудал	Бусад	
Сонгинохайрхан	2024	961	354	232	28	133	107	107
I хэлтэс		310	127	61	5	31	24	62
II хэлтэс		315	175	32	5	39	42	22
III хэлтэс		336	52	139	18	63	41	23
Сонгинохайрхан	2025	1 108	515	253	15	95	86	144
I хэлтэс		416	153	90	8	36	32	97
II хэлтэс		475	340	49	3	20	33	30
III хэлтэс		217	22	114	4	39	21	17
Өсөлт, бууралт хувь		15.3	45.5	9.1	-46.4	-28.6	-19.6	34.6

2025 онд гудамж тайлбайд 1108 хэрэг гарсан нь Сонгинохайрхан дүүрэгт гарсан нийт хэргийн 21.4 хувь болж байна. Тус онд гудамж тайлбайд гарсан нийт хэргийн 515(46.5%) нь гэр хорооллын гудамжинд, 253(22.8%) нь орон сууцны гудамжинд, 15(1.3) нь хүүхдийн тоглоомын талбайд, 95(8.6%) нь ил зогсоол дээр, 86(7.8%) нь автобусын буудал дээр, 144(13.0%) тус тус гарсан байна. Тайлант хугацаанд гудамж талбайд гарсан хэрэг өмнөх оны мөн үеэс 236(34.1%) хэргээр өссөн бөгөөд нийт гудамж, талбайд гарсан хэргийн 241(25.9%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 377(40.6%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 311(33.5%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 11. ОЛОН НИЙТИЙН ГАЗАРТ ҮЙЛДЭГДСЭН ХЭРЭГ

Үзүүлэлт	Он	Олон нийтийн газар	Бөөний худалдааны төв						
			дэлгүүр	зочид буудал	баар	ресторан, зоогийн газар	Авто вокзал	Цайны газар	
Сонгинохайрхан	2024	345	15	51	71	75	3	18	19
I хэлтэс		139	7	14	27	43	1	5	4
II хэлтэс		60	5	14	7	8		2	3
III хэлтэс		146	3	23	37	24	2	11	12
Сонгинохайрхан	2025	375	24	72	53	57	14	18	14
I хэлтэс		150	9	16	29	30	5	6	4
II хэлтэс		63	5	14	7	9	3	1	3
III хэлтэс		162	10	42	17	18	6	11	7
Өсөлт, бууралт хувь		8.7	60.0	41.2	-25.4	-24.0	4.7**	0.0	-26.3

Тайлбар: ** дахин их

2025 онд олон нийтийн газарт 375 хэрэг бүртгэгдсэн нь нийт хэргийн 7.2 хувийг эзэлж байгаа бөгөөд олон нийтийн газарт гарсан нийт хэргийн 57(19.2%) нь дэлгүүрт, 53(14.1%) нь зочид буудалд, 57(15.2%) нь бааранд, 14(3.7%) нь ресторан зоогийн газарт тус тус гарсан байна. Тайлант хугацаанд олон нийтийн газарт гарсан хэрэг өмнөх оны мөн үеэс 30(8.7%) хэргээр өссөн байна. Нийт олон нийтийн газарт гарсан хэргийн 150(40.0%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 63(16.8%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 162(43.2%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

ХҮСНЭГТ 12. НИЙТИЙН ТЭЭВЭРТ ҮЙЛДЭГДСЭН ХЭРЭГ


Үзүүлэлт	Он	нийтийн тээвэр	нийтийн тээвэр		
			том оврын автобус	дунд оврын автобус	такси
Сонгинохайрхан	2024.IX	23	6	6	7
I хэлтэс		10	3	3	2
II хэлтэс		2		0	2
III хэлтэс		11	3	3	3
Сонгинохайрхан	2025.IX	43	8	7	24
I хэлтэс		9	4	1	2
II хэлтэс		6	2	1	2
III хэлтэс		28	2	5	20
Өсөлт, бууралт хувь		87.0	33.3	16.7	3.4**

Тайлбар: ** дахин их

2025 онд нийтийн тээвэрт 43 хэрэг гарсан нь өмнөх оноос 20(87.0%) хэргээр өссөн байна. Тайлант хугацаанд нийтийн тээвэрт гарсан гэмт хэргийн 8(18.6%) нь том оврын автобусанд, 24(55.8%) нь таксид, 7(16.3%) нь дунд оврын автобусанд тус тус үйлдэгдсэн байна. Таксид гарсан хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 4.4 дахин өссөн байна.

Нийтийн тээвэрт гарсан хэргийн 9(20.9%) цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 6(14.0%) цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 28(65.1%) цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 6. ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН БАЙРШИЛ, дүүргээр



Сонгинохайрхан дүүрэгт 2025 онд бүртгэгдсэн нийт хэргийн 450(8.7%) нь аж ахуйн нэгжид, 21(0.4%) нь төрийн байгууллагад, 11(0.2%) нь төрийн бус байгууллагад, 328(6.3%) нь авто зам дээр, 852(16.4%) бусад газарт тус тус гарсан байна. Тайлант хугацаанд аж ахуйн нэгжид гарсан хэргийн 183(40.7%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 105(23.3%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 162(36.0%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст гарсан байна. Төрийн байгууллагад гарсан хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 9(75.0%) хэргээр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 13. ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН ГАЗАР, өмчийн хэлбэрээр

Үзүүлэлт	Он	Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Аж ахуйн нэгж	Авто зам	Бусад
Сонгинохайрхан	2024	12	18	254	225	649
I хэлтэс		5	6	125	132	409
II хэлтэс		3	4	67	59	173
III хэлтэс		4	8	62	34	67
Сонгинохайрхан	2025	21	11	450	328	852
I хэлтэс		9	7	183	196	612
II хэлтэс		9	1	105	83	168
III хэлтэс		3	3	162	49	72
Өсөлт, бууралт хувь		75.0	-38.9	77.2	45.8	31.3

2025 онд хэрэг үйлдсэн хүний тоо 2743 байсан нь өмнөх оны мөн үеэс 768(38.9%) хүнээр өссөн байна. Хэрэг үйлдсэн нийт хүний 363(13.2%) нь эмэгтэй, 102(3.7%) нь 15 хүртэлх насны, 99(3.6%) нь 16-17 настай, 867(31.6%) нь 18-24 настай, 578(21.0%) нь 25-29 настай, 327(11.9%) нь 30-34 настай, 302(11.0%) нь 35-39 настай, 188(6.8%) нь 40-44 настай, 102(3.7%) нь 45-49 настай, 82(3.0%) 50-54 настай, 47(1.7%) нь 55-59 настай, 47(1.7%) нь 60 аас дээш настай байна. Хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдийн тоо өмнөх оноос 54(12.9%) хүнээр, 15 хүртэлх насны хүүхдийн тоо 14(12.1%) ээр буурсан байна.

Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн нийт хүний 1110(40.5%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 726(26.5%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 907(33.0%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст харъяалагдаж байна.

ХҮСНЭГТ 14. ХЭРЭГ ҮЙЛДЭГСЭД, насны бүлгээр

Үзүүлэлт	Нийт			Хэлтэс									
				I хэлтэс			II хэлтэс			III хэлтэс			
	2024	2025	Өсөлт, бууралт хувь	2024	2025	Өсөлт, бууралт хувь	2024	2025	Өсөлт, бууралт хувь	2024	2025	Өсөлт, бууралт хувь	
Бүх хүн	1 975	2 743	38.9	924	1 110	20.1	554	726	31.0	497	907	82.5	
Эмэгтэй	417	363	-12.9	160	131	-18.1	163	109	-33.1	94	123	30.9	
насны бүлэг	15 хүртэлх	116	102	-12.1	51	44	-13.7	25	32	28.0	40	26	-35.0
	16-17	62	99	59.7	15	49	226.7	17	26	52.9	30	24	-20.0
	18-24	499	867	73.7	168	228	35.7	204	120	-41.2	127	519	4.1**
	25-29	300	578	92.7	147	167	13.6	81	305	276.5	72	106	47.2
	30-34	325	327	0.6	179	179	0.0	56	79	41.1	90	69	-23.3
	35-39	232	302	30.2	119	174	46.2	55	58	5.5	58	70	20.7
	40-44	176	188	6.8	95	103	8.4	51	52	2.0	30	33	10.0
	45-49	106	102	-3.8	55	52	-5.5	24	23	-4.2	27	27	0.0
	50-54	76	82	7.9	43	50	16.3	23	14	-39.1	10	18	80.0
	55-59	56	47	-16.1	36	33	-8.3	11	6	-45.5	9	8	-11.1
	60-64	18	26	44.4	8	14	75.0	6	8	33.3	4	4	0.0
	65-69	7	18	2.6**	6	12	100.0	1	3	3**	0	3	3**
	70+	2	5	2.5**	2	5	2.5**	0	0	-	0	0	-

Тайлбар: ** дахин их

ХҮСНЭГТ 15.
ХЭРЭГ ҮЙЛДЭГСЭД, НИЙГМИЙН БАЙДЛААР

Үзүүлэлт	Он	Төрийн албан хаагч	Хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч	Төрийн бус байгууллагын ажилтан	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	Малчин	Оюутан	Сурагч	Сургууль завсардсан хүүхэд, тэнэмэл хүүхэд	Тэнэмэл	Ажилгүй
Сонгинохайрхан	2024	25	150	14	537	18	26	94	49	10	1051
I хэлтэс		16	92	8	302	12	10	46	14		423
II хэлтэс		4	20	1	132	1	7	21	5		363
III хэлтэс		5	38	5	103	5	9	27	30	10	265
Сонгинохайрхан	2025	21	211	10	636	16	39	116	12	9	1670
I хэлтэс		8	145	3	330	14	11	60	5	2	530
II хэлтэс		6	19	4	142	1	8	32	4		510
III хэлтэс		7	47	3	164	1	20	24	3	7	630
Өсөлт, бууралт хувь		-16.0	40.7	-28.6	18.4	-11.1	50.0	23.4	-75.5	-10.0	58.9

2025 оны байдлаар хэрэг үйлдсэн нийт хүний 21(0.8%) нь төрийн албан хаагч, 211(7.7%) нь хувийн хэвшлийн байгууллагад ажиллагч, 10(0.4%) нь төрийн бус байгууллагад ажиллагч, 636(23.2%) нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 16(0.6%) нь малчин, 39(1.4%) нь оюутан, 116(4.2%) нь сурагч, 12(0.4%) нь сургууль завсардсан, 9(0.3%) нь тэнэмэл хүүхэд, 1670(60.9%) нь ажилгүй иргэн байна. Тайлант хугацаанд хэрэг үйлдсэн ажилгүй иргэн өмнөх оны мөн үеэс 619(58.9%) хүнээр өссөн байна.

ХҮСНЭГТ 16.
ХЭРЭГ ҮЙЛДЭГСЭД, БОЛОВСРОЛЫН ТҮВШИНГЭЭР

Үзүүлэлт	Он	Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
Сонгинохайрхан	2024	53	121	234	1285	74	208
I хэлтэс		16	65	125	572	46	100
II хэлтэс		7	23	44	425	13	42
III хэлтэс		30	33	65	288	15	66
Сонгинохайрхан	2025	45	146	297	1940	84	231
I хэлтэс		20	62	135	714	46	133
II хэлтэс		10	41	93	522	28	32
III хэлтэс		15	43	69	704	10	66
Өсөлт, бууралт хувь		-15.1	20.7	26.9	51.0	13.5	11.1

Хэрэг үйлдсэн нийт хүний 45(1.6%) нь боловсролгүй, 146(5.3%) нь бага боловсролтой, 297(10.8%) нь суурь боловсролтой, 1940(70.7%) нь бүрэн дунд боловсролтой, 84(3.1%) нь тусгай мэргэжилийн дунд боловсролтой, 231(8.5%) нь дээд боловсролтой байна.


Тайлант хугацаанд гэмт хэргийн улмаас хохирсон 4933 иргэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 1113(29.1%) хүнээр нэмэгдсэн бөгөөд 2153(43.6%) нь эмэгтэй байна. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн 137(2.8%) 13 хүртэлх насны хүүхэд, 158(3.2%) 14-17 насны, 428(8.7%) 18-24 насны, 486(9.8%) 25-29 насны, 657(13.3%) 30-34 насны, 946(19.2%) 35-39 насны, 701(14.2%) 40-44 насны, 500(10.1%) 45-49 насны, 393(8.0%) 50-54 насны, 242(4.9%) 55-59 насны, 200(5.8%) нь 60, түүнээс дээш насны хүн ам байна.

ХҮСНЭГТ 17. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ИРГЭН, насны бүлгээр

Үзүүлэлт	Нийт									I хэлтэс			II хэлтэс			III хэлтэс		
	Он	2024.	2025	Өсөлт, бууралт хувь	2024	2025	Өсөлт, бууралт хувь	2024.	2025	Өсөлт, бууралт хувь	2024.	2025	Өсөлт, бууралт хувь	2024	2025	Өсөлт, бууралт хувь		
Нийт хохирсон иргэн		3 820	4 933	29.1	1 804	2 321	28.7	1 072	1 257	17.3	944	1 355	43.5					
Эмэгтэй		1 720	2 153	25.2	770	992	28.8	531	485	-8.7	419	676	61.3					
насны бүлэг	7 хүртлэх	31	28	-9.7	10	11	10.0	18	12	-33.3	3	5	66.7					
	8-13	94	109	16.0	43	58	34.9	24	30	25.0	27	21	-22.2					
	14-17	183	158	-13.7	79	79	0.0	60	41	-31.7	44	38	-13.6					
	18-24	379	428	12.9	175	217	24.0	117	97	-17.1	87	114	31.0					
	25-29	409	486	18.8	195	237	21.5	108	131	21.3	106	118	11.3					
	30-34	577	657	13.9	261	297	13.8	158	164	3.8	158	196	24.1					
	35-39	650	946	45.5	313	445	42.2	182	258	41.8	155	243	56.8					
	40-44	484	701	44.8	242	314	29.8	131	178	35.9	111	209	88.3					
	45-49	364	500	37.4	170	224	31.8	93	133	43.0	101	143	41.6					
	50-54	244	393	61.1	126	186	47.6	64	98	53.1	54	109	2**					
	55-59	181	242	33.7	86	123	43.0	51	53	3.9	44	66	50.0					
	60-64	127	151	18.9	56	66	17.9	43	31	-27.9	28	54	92.9					
	65-69	55	76	38.2	26	39	50.0	18	16	-11.1	11	21	90.9					
70 ба түүнээс дээш	42	58	38.1	22	25	13.6	5	15	3**	15	18	20.0						

Тайлбар: ** дахин их

ЗУРАГ 7. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН ХҮН, цагдаагийн хэлтсээр



Тайлант хугацаанд гэмт хэргийн улмаас хохирсон нийт хүний 2321(47.1%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 1257(25.5%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 1355(27.4%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст харъяалагдаж байна.

2025 онд гарсан гэмт хэргийн улмаас 55.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь өнгөрсөн оны мөн үеэс 3.2 дахин их буюу 37.7 тэрбум төгрөгөөр өссөн байна. Хөнгөн гэмт хэргийн улмаас учирсан хохирол 19.6 тэрбум төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс

7.4(60.8%) тэрбум төгрөгөөр, хүнд гэмт хэргийн улмаас учирсан хохирол 35.6 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.7 дхин буюу 30.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 18. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ, сая төгрөгөөр

Үзүүлэлт	Он	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол / сая төгрөг/	хохирол нөхөн төлүүлэлт			
			хөнгөн	хүнд	сая төгрөг	хувиар
Сонгинохайрхан	2024	17 511.5	12 173.7	5 337.8	6 810.8	38.9
I хэлтэс		7 404.0	6 074.8	1 329.2	3 681.7	49.7
II хэлтэс		2 395.3	2 068.5	326.8	1 354.2	56.5
III хэлтэс		7 712.2	4 030.4	3 681.8	1 774.9	23.0
Сонгинохайрхан	2025	55 165.5	19 569.5	35 595.9	14 192.7	25.7
I хэлтэс		45 788.5	11 902.1	33 886.4	8 988.5	19.6
II хэлтэс		3 306.5	2 820.2	486.3	1 637.4	49.5
III хэлтэс		6 070.5	4 847.2	1 223.2	3 566.8	58.8
Өсөлт, бууралт хувь		3.2 дахин их	60.8	6.7 **	2.1**	-

Тайлбар: ** дахин их

Тайлант хугацаанд 56914 зөрчил бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 5615(10.9%) зөрчлөөр нэмэгдсэн байна. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 55734(97.8%) нь шийдвэрлэсэн, 1291(2.2%) нь баривчлуулсан байна.

ХҮСНЭГТ 19. БҮРТГЭГДСЭН ЗӨРЧЛИЙН ТОО, төрлөөр

Үзүүлэлт	Он	Нийт зөрчил	Шийдвэрлэсэн зөрчил	
			Шийдвэрлэсэн зөрчил	Баривчлуулсан
Сонгинохайрхан	2024	51 299	50 637	1 603
I хэлтэс		18 141	17 817	670
II хэлтэс		11 680	11 449	429
III хэлтэс		21 478	21 371	504
Сонгинохайрхан	2025	56 914	55 734	1 291
I хэлтэс		21 607	20 955	472
II хэлтэс		12 125	11 874	318
III хэлтэс		23 182	22 905	501
Өсөлт, бууралт хувь		10.9	-63.7	-19.5

Сонгинохайрхан дүүрэгт 2025 онд гарсан нийт зөрчлийн 21607(38.0%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 12125(21.3%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 23182(40.7%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн гаралтыг хороогоор харвал 32-р хороонд 260(5.1%), 12-р хороонд 255(4.9%), 29-р хороонд 250(4.8%), 10-р хороонд 234(4.5%), 20-р хороонд 227(4.4%), 19-р хороонд 224(4.3%) тус тус гэмт хэрэг бүртгэгдсэн нь хамгийн их хувийг эзэлж байна. Харин дээрхи хороодыг өмнөх өны мөн үетэй харьцуулахад 32-р хороо 65(33.3%), 12-р хороо 111(77.1%), 29-р хороо 62(33.0%), 10-р хороо 147(2.6 дахин их), 20-р хороо 72(46.5%), 19-р хороо 41(22.4%) тус тус гэмт хэргийн гаралт өссөн байна. Харин хамгийн бага гэмт хэрэг гарсан нь 35-р хороонд 29(0.6%), 43-р хороонд 30(0.6%), 42-р хороонд 42(0.8%) тус тус гэмт хэрэг бүртгэгдсэн байна.


ХҮСНЭГТ 20.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, хороогоор, оноор

Хороо	2024				2025				Өсөлт, бууралт	
	Нийт хэрэг	ХБ хэрэг	Яллагдагчаар татсан	Илрүүллийн хувь	Нийт хэрэг	ХБ хэрэг	Яллагдагчаар татсан	Илрүүллийн хувь	Нэгж	Илрүүлэлт өсөлт, бууралт
1	64	63	28	44.4	87	83	39	47.0	23	2.5
2	83	81	41	50.6	94	89	45	50.6	11	-0.1
3	67	64	44	68.8	68	67	30	44.8	1	-24.0
4	80	78	36	46.2	113	107	46	43.0	33	-3.2
5	64	62	34	54.8	64	63	26	41.3	0	-13.6
6	103	99	37	37.4	132	130	49	37.7	29	0.3
7	95	88	41	46.6	149	140	70	50.0	54	3.4
8	77	68	40	58.8	107	102	49	48.0	30	-10.8
9	99	96	58	60.4	131	128	85	66.4	32	6.0
10	89	83	41	49.4	234	230	186	80.9	145	31.5
11	93	90	37	41.1	108	107	45	42.1	15	0.9
12	144	140	55	39.3	255	252	181	71.8	111	32.5
13	65	62	25	40.3	122	121	73	60.3	57	20.0
14	113	109	71	65.1	118	115	45	39.1	5	-26.0
15	71	69	27	39.1	105	104	57	54.8	34	15.7
16	77	77	33	42.9	152	152	79	52.0	75	9.1
17	102	99	43	43.4	124	124	78	62.9	22	19.5
18	104	101	39	38.6	151	148	60	40.5	47	1.9
19	183	177	112	63.3	224	210	72	34.3	41	-29.0
20	155	148	54	36.5	227	221	82	37.1	72	0.6
21	93	90	38	42.2	139	137	44	32.1	46	-10.1
22	80	74	32	43.2	102	97	51	52.6	22	9.3
23	47	46	16	34.8	94	93	67	72.0	47	37.3
24	105	98	37	37.8	147	141	72	51.1	42	13.3
25	77	69	44	63.8	88	83	30	36.1	11	-27.6
26	73	65	33	50.8	83	81	37	45.7	10	-5.1
27	122	116	55	47.4	196	193	83	43.0	74	-4.4
28	80	73	27	37.0	63	60	25	41.7	-17	4.7
29	188	182	80	44.0	250	245	129	52.7	62	8.7
30	39	35	19	54.3	51	50	28	56.0	12	1.7
31	54	52	25	48.1	55	53	24	45.3	1	-2.8
32	195	191	84	44.0	260	247	84	34.0	65	-10.0
33	149	138	65	47.1	192	182	77	42.3	43	-4.8
34	83	76	31	40.8	123	122	55	45.1	40	4.3
35	22	21	6	28.6	29	26	6	23.1	7	-5.5
36	77	75	33	44.0	74	71	35	49.3	-3	5.3
37	204	199	107	53.8	142	137	46	33.6	-62	-20.2
38	53	49	22	44.9	81	78	39	50.0	28	5.1
39	24	22	8	36.4	55	55	37	67.3	31	30.9
40	73	66	21	31.8	52	50	24	48.0	-21	16.2
41	62	53	22	41.5	69	68	37	54.4	7	12.9
42	39	35	12	34.3	42	38	13	34.2	3	-0.1
43	31	27	16	59.3	30	30	12	40.0	-1	-19.3
Нийт	3898	3706	1729	46.7	5182	5030	2452	48.7	1284	2.1

ЗУРАГ 8.

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, хороогоор, оноор



*Сонгинохайрхан дүүргийн
статистикийн хэлтэст эмхэтгэн
гаргав.*

Статистик 
Мэдээ, мэдээлэл 
Номын сан 
Мэдлэгээ шалгах тоглоом 
Валютын ханш 



©2017

аппликэйшнаас
СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab | тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



www.facebook.com/StatisticMongolia/



www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn